

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234719

**“МОНГОЛ ҮГ БИЧИГ” ДЭВТЭР ДЭХ “МОНГОЛЫН НУУЦ
ТОВЧООН”-Ы ТУХАЙ**

*“Монгол үг бичиг” дэвтэр дэх “Монголын нууц
товчоон”-ы 100 жилийн ойд зориулав*

Х.Цогтнаран
Б.Түвшинтөгс

Товчлол: Энэхүү өгүүлэлд зохиогчид Япон улсын Васэда Их Сургуулийн номын сангийн хөмрөгт хадгалагдаж буй “Монгол үг бичиг” хэмээх нөхөж бичсэн гарчигтай дэвтэрт тэмдэглэсэн Монголын нууц товчооны талаар өгүүлсэн байна. Уг дэвтрийг чухам хэн, хэзээ, юунд хэрэглэж байсан нь тодорхойгүй бөгөөд харин тус сургуульд Тэрада Тошикуни гэдэг хүн хадгалуулахаар өгсөн тухай тэмдэглэл л үлджээ. Иймээс зохиогчид дэвтэрт тэмдэглэсэн бичвэрийн агуулгаас үндэслэн зохиогчийн талаар санал дэвшүүлж мөн уг дэвтэрт буй монгол бичгээр тэмдэглэсэн Монголын нууц товчоон нь одоогийн олдсон баримтаас үзэхэд Япон улс дахь магадгүй япон хүний хийсэн хөрвүүлэг ба орчуулгын анхны оролдлого хэмээн үзсэн болно. Мөн монгол хэл бичгийг заах зорилгоор Монголын нууц товчооныг сурах бичигт оруулсан анхны тохиолдлуудын ч нэг гэж дүгнэсэн байна.

Түлхүүр үг: Монголын нууц товчоон, “Монгол үг бичиг” дэвтэр, Васэда Их Сургуулийн номын сан

Япон улсын Васэда Их Сургууль (早稲田大学 Waseda daigaku)-ийн номын сангийн хөмрөгт 5/2302 дансны дугаартай 18x26 см-ийн хэмжээтэй, 178 нүүр бүхий нэгэн бичмэл дэвтэр хадгалагдаж байна. Уг дэвтрийн хавтсан дээр харандаагаар монгол бичгээр *tayīšo 12-13 on-dur surγaysan Mongγul üge bičig. terada* [Тайшо 12-13 онд сургасан Монгол үг бичиг. Тэрада] хэмээн гарчиг тавьжээ (зураг 1). Ийнхүү “Монгол үг бичиг” хэмээн гарчиг тавьж, мөн “Тайшо 12-13 онд сургасан” хэмээн тэмдэглэснээс үзэхэд уг дэвтэр нь Япон улсад монгол хэл, бичиг заах эс бөгөөс сурахдаа хэрэглэж байсан нь тодорхой байна. “Тайшо” гэдэг нь Японы уламжлалт оны цол болох тул “тайшогийн 12-13 он” гэдэг нь аргын тус тус 1923, 1924 он болно. Мөн “Тэрада”¹ хэмээх нэр бийгээс үзвэл энэ нь уг дэвтрийг эмхэтгэн зохиосон хүн эсвээс монгол хэл, бичгийн хичээлээ тэмдэглэн бичсэн суралцагчийн нэр байх магадлалтай юм. Дэвтрийн дотор нүүрт “昭和三十七年四月十四日寺田利邦氏寄贈” хэмээх тэмдэглэл буй (зураг

¹ Номын хавтсан дээрх монгол бичгээр тэмдэглэсэн нэр Derewa буюу Dereweа хэмээн бичсэн мэт харагддаг. Харин хавтасны дотор нүүр дэх Японоор бичсэн 寺田利邦 гэдгээс номын хавтсан дахь монголоор бичиж байгаа нэр нь Dereda болох нь мэдэгдэнэ.

2). Энэ тэмдэглэлээс уг дэвтрийг 1962 онд Тэрада Тошикуни (寺田利邦氏 Terada Toshikuni) бээр дээр дурдсан Васэда Их Сургуулийн номын санд бэлэглэсэн гэдгийг мэдэж болно. Иймээс энэ дэвтэр 1962 оноос өмнө Тэрада Тошикунигийн гарт байсан гэдэг нь тодорхой. Харин одоогоор бидэнд Тэрада Тошикунигийн намтар, үйл ажиллагаатай холбогдох тодорхой баримт олдсонгүй. Тэрээр 1962 онд хувийн ном дэвтрээ² Васэда Их Сургуульд хандивлаж байснаас үзэхэд тус сургуульд багшилж байсан юм уу өөр ямар нэг харилцаатай байсан бололтой. 1978-1997 оны хооронд гарсан 早稻田大学百年史 [Васэда Их Сургуулийн 100 жилийн түүх] хэмээх цуврал бичгийн хавсралт ботийн хоёрдугаар эмхэтгэлийн гуравдугаар хэсэгт Тэрада Тошикуни гэдэг тус сургуулийн инженерийн салбарт суралцаж төгсөөд техник технологийн чиглэлийн багш болсон нэгэн хүний тухай товч танилцуулга бий ч энэ нь бидний дурдан буй “Монгол үг бичиг” хэмээх дэвтэртэй холбоотой Тэрада Тошикуни мөн эсэхийг тодруулахад хангалттай биш юм. Харин уг “Монгол үг бичиг” хэмээх дэвтрийн дотор жишээ болгосон бичвэр дунд *Туйлын өршөөлт Камияа багш Танаа, Эрхэм багш Камияа Кохэ Танаа, Өршөөлт Камияа багш Танаа* гэх зэргээр шавь Гомбо, Ачанга нараас удаа дараа бичсэн захидлууд бий. Мөн “*Энэ учрыг та нар шавь нар бүгдээр мэдэж байна. Гэвч би монголоор бичиж өгье*”, “*Энэ хэн байдаг, ямар улс билээ. Та нар эрхэм шавь нар над учраа гаргаж сайтар бичиж өгнө үү*” гэх зэргээр багшийн зүгээс хандсан үг хэдэнтээ тэмдэглэжээ. Энд нэр дурдагдсан Камияа Кохэ нь 1902-1905 онд Токиогийн Гадаад хэлний Сургуульд хятад хэлний мэргэжлээр суралцсан ба төгсөөд Цэргийн сургуульд багшилж байгаад 1920-оод оны эхнээс Токиогийн Гадаад хэлний Сургуулийн багш болжээ. Тэр бээр хятад хэлнээс япон хэл рүү олон тооны ном орчуулсан төдийгүй 蒙古語入門 [Анхан шатны монгол хэл] (Камияа Кохэ. 1919)³ гэдэг ном бичиж хэвлүүлсэн, түүнчлэн тухайн үед Япон улсад хэвлэгдсэн монгол хэлний хэд хэдэн номыг редакторласан ба өмнөх үг бичсэн байна⁴. Иймд энэхүү дэвтрийг Камияа Кохэ эмхэтгэн бэлдсэн ч байж болох юм. Өөрөөр хэлбэл энэ дэвтрийг Токиогийн Гадаад хэл судлалын Их Сургуулийн багш Камияа Кохэ, эс бөгөөс түүнтэй ажил хэргийн холбоотой хэн нэгэн найруулж үзгээр бичсэн ба тэрхүү дэвтрийг Тэрада Тошикуни хичээл сурлагадаа ашиглахдаа харандаагаар тэмдэглэл хийсэн болов уу. Ташрамд тэмдэглэхэд энэхүү “Монгол үг бичиг” дэвтэрт буй Намсрай гэгч Лувсангаар зуучлуулан Дашдорж хэмээгчээс тарианы газраа барьцаанд тавьж мөнгө зээлсэн учрыг батлан тэмдэглэсэн “Тэрээ бичиг байгуулахын учир” (зураг 3) хэмээх бичвэрийг Мантаро Сүзүэ (1923:62-65) 蒙古文範 *Specimens of Mongolian writings* хэмээх номдоо хүний нэрүүдийг нь үл дурдан тэр хэвээр хэвлүүлсэн байна (зураг 4). Ингэхдээ мөн уг гэрээнд нэмж хавсаргасан зүйлийн эхийг хамт оруулжээ. Энд дурдагдан буй Мантаро Сүзүэ (1886-1929) нь Японы Токиогийн Гадаад хэлний

² Тус хөмрөгт мөн түүний бэлэглэсэн 蒙古語単語帳 Mokogo tangocho [Монгол үгийн дэвтэр] хэмээх 14x23 см хэмжээтэй Notebook гэсэн 5 дэвтэр гар бичмэл япон-монгол толь бичиг бий.

³ Камияа Кохэ өөрийнх нь энэ номыг Английн J. Whymant *A Mongolian grammar* (London, 1926) бүтээлдээ ашигласныг бахархан тэмдэглэсэн байдаг.

⁴ Тухайлбал тэрбээр Кожима Такэо 蒙古語會話 [Монгол хэлний яриа]. Тэнри Гадаад хэлний Их Сургууль. Токио Бункюдо хэвлэлийн газар. Шовагийн 13-р он (1938) номыг редакторлож, мөн түүний 蒙古語文典 [Монгол хэлний хэлзүй]. Токио, Тоёо Бункюдо хэвлэлийн газар. Шовагийн 16-р он (1941) номд өмнөх үг бичжээ.

Сургуульд монгол хэл сурсан бөгөөд 1928 оноос Осакагийн Гадаад хэлний Сургуульд монгол хэлний багшаар ажиллаж байжээ. Багшлахаасаа урьд Японы армид алба хааж байсан ба дэд хурандаа цолтой юм. Тэр бээр армид байхдаа цэргийн хэрэгцээнд зориулан хурандаа Шимунага Кэнжитэй хамтран 蒙古語大辞典 [Монгол хэлний их тайлбар толь] зохион хэвлүүлсэн байна (Сүзүэ Мантаро, Шимунага Кэнжи. 1933). Шимунага Кэнжи үүнээс гадна монгол хэл сурахад зориулж хэд хэдэн ном хэвлүүлсний дотор Тайшогийн 12-р он буюу аргын 1923 онд хэвлүүлсэн *Mongyul kele bicig kilbar surqu ary-a* 蒙古語捷徑 номонд нь Камия Кохэ, Сүзүэ Мантаро нар өмнөх үг бичиж байжээ. Өөрөөр хэлбэл бидний толилуулан буй “Монгол үг бичиг” дэвтрийг эмхэтгэн бичсэн болов уу хэмээн таамаглаж буй Камия Кохэ хийгээд уг дэвтэрт буй гэрээний бичгийг тэр хэвээр бүтээлдээ хэвлэн нийтэлсэн Мантаро Сүзүэ, мөн монгол хэл бичигт суралцах хэд хэдэн ном хэвлүүлсэн Шимунага Кэнжи нар ажил хэргийн дотно холбоотнууд байсан ажээ.

Энэхүү “Монгол үг бичиг” хэмээх дэвтэр нь унших бичгийн шинжтэй юм. Өөрөөр хэлбэл, олон зохиолоос хэсэглэн авч эмхэтгэн дэвтэрлэсэн байна. Тухайлбал, *Монгол улсын хуучин үг, Буян нүгэл, Сонин сонсгол, Жибэн улсын учир, Монголын түүх, Хөлөнбуйр мужийн загас ашигласан учирт, Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичиг, Буриад улс ба тэдгээрийн ажил, Баруун хойдох хязгаарын хэргийг бодуулан шийтгэгч сайд бөгөөд Гадаад Монголын хойчийг сайжруулах элдэв хэрэг зүйлийг ерөнхийлөн шийтгэгч Сюйгийн бичиг, Оюун түлхүүр, Жибэн, Дундад Улсын зүүн монгол газрын холбогдолд тогтсон болзоо, Бүрэн эрхт Монгол улс, Монголын нууц товчоо, Халиун бялзуухай хийгээд хав загас, Буудай, Төмөр, Цагаан хэрэм* зэрэг зохиол байхаас гадна гарчиггүй нэлээд хэдэн шүлэг, зүйр үг, захидал, гэрээ бичгийн загвар зэрэг буй. Эдгээрээс бидний анхаарал татах зүйл нь “Монголын нууц товчоон” хэмээх хэсэг болно. Энэ нь Монголын нууц товчооны нэгдүгээр бүлэг буюу даруй 1-68-р зүйлийн хөрвүүлэг юм. Уг хөрвүүлэг нь тус номын 133-150-р нүүрт буй. Харамсалтай нь арваад нүүрийн бичвэр нэлээд балархай болсон байна. Харин Монголын нууц товчооны хөрвүүлгийн эхлэл хэсэгт 第三学期 [Гуравдугаар сурлагын хугацаа] хэмээн тэмдэглэснийг үзвэл үүнээс хойших хэсгийг монгол хэлний нэлээд мэдлэгтэй болсны хойно уншихаар заасан гэж ойлгогдоно.

“Монгол үг бичиг” дэвтэр дэх Монголын нууц товчоон бие даасан хөрвүүлэг болохын учир

“Монгол үг бичиг” дэвтэр дэх Монголын нууц товчооны хэсгийг нарийвчлан үзвэл урьд өмнөх хэн нэгний хийсэн сийрүүлэл буюу хөрвүүлгийн хуулбар биш, харин бие даасан хөрвүүлэг гэж хэлж болохоор байна.

Уг хэсгийн эхэнд “Монголын нууц товчоон” хэмээн гарчиг тавьж, *Товчоон* гэдгийн ард 缩集 хэмээн хадмал орчуулга хийжээ. Улмаар “Чингис хааны язгуур” гэдгийг нэг мөр эзлүүлэн хөрвүүлгээ эхлүүлсэн байна (зураг 5). Тухайн хөрвүүлгийн агуулга дахь үгсийг нягтлан үзвэл Монголын нууц товчоонд гарах 𐰆𐰪𐰨 (可温) гэдгийг цөм 𐰆𐰪 гэж, 𐰆𐰪𐰨 (可兀秃) гэдгийг 𐰆𐰪 буюу 𐰆𐰪 гэж, 𐰆𐰪𐰨 (古温) гэдгийг цөм 𐰆𐰪 гэж, 𐰆𐰪𐰨 (訶额命) гэдгийг цөм 𐰆𐰪 гэж хөрвүүлсэн байна.

Төгсгөлд “Монголын нууц товчооны нэгдүгээр дэвтэр төгсөв” хэмээн бичиж ард нь 蒙古—秘—集 (元朝秘史) 第一本終 хэмээх орчуулга хадсан байна. Мөн Монголын нууц товчооны хөрвүүлгийн зэрэгцээ мөр хооронд болон цаасны захаар олон тооны монгол, япон, хятад хэлний орчуулга, тайлбар хийжээ.

Дээр дурдсан зүйлсээс хэдэн чухал мэдээлэл тодорхой болж байна. Үүнд:

Нэгд, Хөрвүүлэгч уг зохиолыг шууд “Монголын нууц товчоон” хэмээн нэрлэсэн байна. Монголын нууц товчооны хэд хэдэн хуулмал эх уламжлан ирсний дотор одоо мэдэгдэж буйгаар “Монголын нууц товчоон” гэдэг нэр анх тэмдэглэгдсэн дэвтэр бол 1804 оны 15 бүлэгт хуулмал дэвтэр юм. Уг дэвтэрт 元朝秘史 (Yuan-chao mi-shi) гэдэг нэрийн доор “Монголын нууц товчоон” гэдгийг 忙豁侖紐察脱察安 (mang-huo-lun niu-cha tuo-cha-an) гэж 8 ханз үсгээр галиглан бичсэн байдаг. Гэвч XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн хэдэн монгол хөрвүүлгийг ажиглахад цөм “Монголын нууц товчоон” гэдэг нэрийг хэрэглэсэнгүй, харин “Юань улсын нууц түүх” буюу “Юань-чао ми-ши” хэмээн хэвээр бичсэн байдаг билээ. Харин “Монгол үг бичиг” хэмээх энэхүү унших бичигт анх удаа монгол бичгээр “Монголын нууц товчоон” хэмээн тэмдэглэсэн байна. Ер нь Чингис хааны бодит амьдралын түүхийг өгүүлсэн энэхүү зохиолыг анх монгол бичгээр туурвисан агаад угтаа 忙豁侖紐察脱卜察安 (mang-huo-lun niu-cha tuo-ba-cha-an) ийм нэртэй байсан гэдгийг Японд Монголын нууц товчооныг анхлан орчуулсан Нака Мичиё тэмдэглэсэн (1907:1) байдгийг хөрвүүлэгч харгалзан үзсэн бололтой.

Хоёрт, Номын эхэн дэх “Монголын нууц товчоон” хэмээх гарчгийн “товчоон” гэдгийг япон хэлээр 缩集 хэмээн орчуулсан нь маш сонирхолтой, орчуулагчаас “товчоон” гэдэг үгийг товчилсон буюу хураангуйлсан гэдэг утгатай хэмээн үзсэн явдал болно. Ер нь Японы монгол судлалын эхэн үеийн төлөөлөгчид, тухайлбал Нака Мичиё уг 脱察安 (tuo-cha-an) хэмээх үгийг “түүхийн тоймчилсон тайлбар” гэсэн утгатай хэмээн үзэж байсан билээ (1907:2).

Гуравт, Зохиогч Монголын нууц товчооны хөрвүүлгийнхээ эхэнд “Чингис хааны язгуур” гэсэн хэсгийг дангаар нь нэг мөр эзлүүлэн бичсэн байна. Үүнээс тус хөрвүүлэг нь 12 бүлэгт Монголын нууц товчооны эх дэвтэрт суурилсан болохыг мэдэж болно. Учир нь 12 бүлэгт эх дэвтэрт “Чингис хааны язгуур” гэдгийг нэг мөр эзлүүлэн бичсэн байдаг бол 15 бүлэгт эх дэвтэрт “Чингис хааны язгуур” гэдгийн доороос шууд залгуулан бичсэн байдаг.

Мэдээж алдаатай зүйл олон байгаа ч энэхүү хөрвүүлэг нь өвөрмөц, бие даасан шинжтэй бүтээл юм.


“Монгол үг бичиг” дэвтэр дэх Монголын нууц товчооны эхийн тухай

“Монгол үг бичиг” хэмээх дэвтэрт тэмдэглэсэн “Монголын нууц товчоон”-ыг чухам ямар эх бичигт суурилан хөрвүүлснийг тодорхойлоход юуны өмнө 1920-оод оноос өмнө Япон улсад уламжлагдан хүрч тухайн цаг үед ашиглах боломжтой байсан Монголын нууц товчооны эх дэвтрүүдтэй харьцуулал хийх хэрэгтэй юм.

Одоогоор олдсон баримтаас үзэхэд Япон улс дахь Монголын нууц товчооны судлал XIX зууны сүүлчээс эхэлсэн хэмээн үзэж болно. Тодруулбал, 1898 онд

Япон улсын бичигтэн Ямамото Санияа (山本子明) Чин улсын үеийн бичигтэн Жан Му (张穆 1805-1849)-ын хэвлүүлсэн Монголын нууц товчооны хураангуй орчуулгад суурилан судалгааны бүтээл нийтэлсэн нь Япон улс дахь Монголын нууц товчоон судлалын эхлэл болсон байна. Мөн энэхүү бүтээл нь Япон улс дахь 15 бүлэгт Монголын нууц товчооны анхны судалгаа болно.

Харин Япон улсад 12 бүлэгт Монголын нууц товчоонд суурилсан судалгаа хожуу XX зууны эхэнд эхэлсэн ажээ. Тухайлбал, Чин улсын үеийн бичигтэн Вэнь Тинши (文廷式 1856-1904) 1885 онд Чин улсын үеийн бичигтэн Гү Гүаньчи (顾广圻 1766-1835)-ийн хянан хуулуулсан 12 бүлэгт Монголын нууц товчооноос хуулсан дэвтрээ 1901 онд дахин нэг хувь хуулж Япон улсын эрдэмтэн Найто Конан (内藤湖南 1866-1934)⁵-д илгээсэн байна. Ингэснээр 1901 оны сүүл гэхэд 6 боть бүхий 12 бүлэгт Монголын нууц товчооны хуулмал дэвтэр Найто Конаны гарт оржээ. Найто Конан тэр даруйд нь тухайн хуулмал дэвтрийг дахин нэг хувь хуулж түүнийгээ Япон улсын эрдэмтэн Нака Мичиё (那珂通世 1851-1908)-д өгсөн байна. Энэхүү хуулмал дэвтэр одоо Япон улсын Цүкүба Их Сургууль (筑波大学)-ийн номын санд хадгалагдаж буй. Харин Найто Конаны өгсөн хуулмал дэвтрээс Нака Мичиё дахин нэг хувь хуулсан нь одоо Япон улсын Васэда Их Сургууль (早稻田大学)-ийн номын санд хадгалагдаж байна. Вэнь Тиншигийн Найто Конанд илгээсэн анхны хуулмал дэвтэр одоо Япон улсын Киото Их Сургууль (京都大学)-ийн Хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнд хадгалагдаж буй. Энэ хуулбар дэвтрээс дахин нэг хуулж авсан нь Япон улсын эрдэмтэн Ишихама Жюнтаро (石濱純太郎 1888-1968)-д хадгалагдаж байгаад хожим Япон улсын Осака Их Сургууль (大阪大学)-ийн номын санд түүний цуглуулгын хамт шилжсэн байна. Ийнхүү Япон улсад 12 бүлэгт Монголын нууц товчоон анх уламжлан хүрсэн ба түүнийг цааш нь хуулан дэлгэрүүлсэн ажээ. Үүнийг мөн Нака Мичиё бүтээлдээ хүснэгтлэн үзүүлсэн нь бий (зураг 6).




“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчооныг нягталбал 13-р нүүрийн 6-р мөрд 阿都 (a-du) хэмээх үг бий. Уг үг нь Монголын нууц товчооны 12 бүлэгт эх дэвтэрт 阿鄰 (a-lin) гэж байдаг бол 15 бүлэгт дэвтэрт түүнийг 阿卜鄰 (a-ba-lin) хэмээн бичсэн байдаг.

⁵ Найто Конан – Японы дорно дахин судлаач эрдэмтэн, Япон дахь Монголын нууц товчооны судлалын үндсийг тавигчдын нэг. Тэрбээр 1902 онд Япон улсын Осака хотноо хэвлэгддэг 大阪朝日新聞 [Осакагийн өглөөний сонин] сонинд олон нийтэд зориулан 蒙古元朝秘史 [Монгол хэлээрх Монголын нууц товчоон] хэмээх нийтлэл хэвлүүлсэн байна. Түүний намтар, эрдэм шинжилгээний ажлын талаар дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү: (Tsogtnaran Kh. 2022:65).

1901 онд Вэнь Тиншигийн Японд илгээсэн Монголын нууц товчооны хуулмал дэвтэр хийгээд түүнээс салбарласан бусад хуулмал дэвтрийг нягтлан үзэхэд 阿鄰 (a-lin) гэхийг цөм 阿都 (a-du) хэмээн бичсэн байна. Харин Вэнь Тиншигийн анх эх материал болгон хуулсан Гү Гүаньчигийн хянан хуулуулсан дэвтэр хийгээд бусад 12 бүлэгт Монголын нууц товчооны эх дэвтэрт цөм 阿鄰 (a-lin) хэмээн зөвөөр бичигдсэн байдаг. Үүнээс үзэхэд Вэнь Тинши анх 阿鄰 (a-lin) гэхийг 阿都 (a-du) хэмээн алдаатай хуулж, түүнээс салбарласан бусад хуулмал дэвтэр нь ч цөм уг алдааг давтсан гэдэг нь эндээс харагдана.

Энэхүү жишээ бол “Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчооныг хөрвүүлэгч чухам ямар эхийг ашигласан гэдгийг тодруулахад чухал баримт болох юм. Өөрөөр хэлбэл, зөвхөн Вэнь Тиншигийн хуулмал дэвтэр болон түүнээс хуулсан бусад дэвтэрт байгаа алдаа бидний толилуулан байгаа “Монгол үг бичиг” дэвтэр дэх Монголын нууц товчоонд мөн буй тул хөрвүүлэгч 12 бүлэгт эх дэвтрийн Японд буй хувилбаруудын аль нэгийг ашигласан нь тодорхой юм. Ялангуяа Тэрада Тошикуни нь Васэда Их Сургуультай холбоотой байсан нь хэд хэдэн баримтаар тодорхой тул түүний бэлэглэсэн “Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчоон нь Васэда Их Сургуулийн номын санд хадгалж байгаа Нака Мичиёгийн хуулсан 12 бүлэгт Монголын нууц товчоонд суурилсан байх хэмээн үзэж болно.



Зураг 6. Япон улсад “Монголын нууц товчоон” анх уламжлан хүрсэн ба түүнийг цааш цааш нь хуулан дэлгэрүүлсэн байдлыг үзүүлсэн Нака Мичиёгийн хүснэгт

“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчооныг хөрвүүлсэн он цаг

“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчооныг хэдийд хөрвүүлсэн бэ гэдгийг тогтооход уг дэвтрийн хавтсан дахь “Тайшо 12-13 онд сургасан” хэмээх тэмдэглэл чухал баримт болж чадна. Учир нь Тайшогийн 12, 13-р он нь аргын 1923, 1924 онтой дүйх тул уг хөрвүүлгийг дээрх оноос өмнө хийсэн гэдгийг мэдэж болно. Мөн уг бичмэл дэвтэрт Монголын нууц товчооны хөрвүүлгээс гадна өөр бусад зохиол байгааг дээр дурдсан билээ. Түүний дотор Дундад Иргэн Улсын 4-р оны таван сарын 25-ны өдөр Бээжинд тогтоосон Япон-Дундад Иргэн Улс хоёрын гэрээний бичиг, 1916 оны үеийн “Нийслэл Хүрээний сонин бичиг”-ийн мэдээ, нийтлэлүүд, Дундад Иргэн Улсын 9-р оны хоёр сарын гурванаар огноолсон *Баруун хойдох хязгаарын хэргийг бодуулан шийтгэгч сайд бөгөөд Гадаад Монголын хойчийг сайжруулах элдэв хэрэг зүйлийг ерөнхийлөн шийтгэгч Сюйгийн бичиг* зэрэг 1920-оод оны үеийн зүйлийг бичжээ. Түүнчлэн шавь нартайгаа 3 сарын сүүлээр авах шалгалтын талаар харилцан ярианы байдалтай бичсэн зүйлийн хойно 20/II 13, мөн түүний хойхон одоогоос 3-4 мянга илүү жилийн өмнө зүүн нар мандах зүг дэх Гадаад их далайн⁶ дунд нэгэн өмнө хойшоогоо урт ихшиг арал байдаг тухай өгүүлсэн зүйлийн дараа “Энэ хэн байдаг, ямар улс билээ. Та нар эрхэм шавь нар над учраа гаргаж сайтар бичиж өгнө үү” гээд 22/II 13 гэсэн огноо тавьжээ. Энэ бол уг дэвтэрт эдгээр зүйлийг бичсэн огноо болов уу. Өөрөөр хэлбэл энд буй 13 он гэдэг нь Японы уламжлалт он тооллын Тайшогийн 13-р оныг зааж буй хэмээн болох бөгөөд энэ нь аргын 1924 онтой дүйнэ.

“Монгол үг бичиг” хэмээх дэвтрийн хавтас дээрх “Тайшогийн 12-13-р он” гэсэн тэмдэглэлийг бид уг унших бичгийг хичээл сурлагад ашиглаж эхэлсэн он цаг хэмээн үзэж байгаа билээ. Тиймээс энэхүү дэвтэрт тэмдэглэсэн зохиолууд нь дээрх оноос өмнө хэвлэгдсэн байх нь дамжиггүй бөгөөд Тэрада Тошикунигийн тэмдэглэсэн Монголын нууц товчооны хөрвүүлэг ч гэсэн ямартаа ч Тайшогийн 12-р он буюу аргын 1923 он гэхэд хийж дууссан байсан нь лавтай хэмээн таамаглаж байна.

“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчооны байр суурь

“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчоон нь XX зууны эхэн дэх Монголын нууц товчооны орчуулга, хөрвүүлгийн дотор он цагийн хувьд нэлээд эртний байр суурь эзлэхүйц бүтээл билээ.

XX зууны гучаад он хүртэлх хугацаанд Монголын нууц товчооны монгол хөрвүүлэг ба орчуулгыг хийсэн эрдэмтэн гэвэл Оросын монголч эрдэмтэн А.М.Позднеев (1851-1920), Бодлогот гүн Цэнд (1875-1932), Япон улсын эрдэмтэн Широ Хаттори (服部四郎 1908-1995) болон Өвөр Монголын эрдэмтэн Хуасай Дугаржав (1911-2013) нарыг дурдаж болно.

⁶ Өнөөгийн Номхон далайг ийнхүү нэрлэдэг байв.

⁷ Дэс дарааллын хувьд II гэж байх байсан болов уу гэж санагдана.

А.М.Позднеев Монголын нууц товчооны 1-96-р зүйлийг галиглаж, монгол бичгээр сэргээн бичиж *Транскрипция палеографического текста Юань-чао ми-ши* [Юань-чао ми-ши хэмээх сурвалжийн эртний бичлэгийн галиг] (зураг 7) гэдэг бүтээлийг 1897 онд чулуун бараар хэвлэсэн байна. Уг бүтээл нь одоогоор мэдэгдэж буй Монголын нууц товчооны анхны монгол бичгийн сэргээлт юм.

Богд хаант Монгол Улсын Бодлогот гүн Цэнд нь Монголын нууц товчооныг монгол бичгээр хөрвүүлэх, монгол хэлээр орчуулах ажлыг хийсэн анхны монгол хүн билээ. Тэр бээр 1910-аад оны дундуур Их Хүрээнд байхдаа Ей Дэхуйгийн барлан хэвлүүлсэн 12 бүлэгт Монголын нууц товчооныг монгол бичгээр галиглах, мөн монгол хэлээр орчуулах ажлыг хийж 1917 онд дууссан⁸ байна.

Японы эрдэмтэн Ш.Хаттори, тухайн цагт тус улсад суралцаж асан Хуасай Дугаржав нар хамтран Ей Дэхуйгийн барлан хэвлүүлсэн 12 бүлэгт Монголын нууц товчооны нэгдүгээр бүлэг буюу 1-68 зүйлийг монгол бичгээр хөрвүүлэн 1939 онд 蒙文元朝秘史卷一 [Монгол үсгийн Монголын нууц товчоо. Нэгдүгээр дэвтэр] хэмээх бүтээл хэвлүүлжээ. Ингэхдээ уг нэгдүгээр бүлэгт тохиолдох хүний нэр, овог аймгийн нэр, газрын нэр зэргийн цэс хийж өгсөн нь уншигчдад дөхөм болсон байна.

Дээр дурдсан зүйлс бол Монголын нууц товчооныг XX зууны гучаад он хүртэл монгол бичигт хөрвүүлсэн ба монголоор орчуулсан байдлын тойм билээ. Эдгээрийн он цагтай бидний толилуулан буй “Монгол үг бичиг” дэвтэр дэх Монголын нууц товчооныг харьцуулан үзвэл А.М.Позднеевийн галиглаж сэргээсэн Монголын нууц товчоон болон Цэнд гүнгийн орчуулж, хөрвүүлсэн Монголын нууц товчооны дараа орох нь тодорхой юм. Нөгөөтээгүүр одоогийн олдсон баримтаар үзэхэд тус хөрвүүлэг нь Япон улс дахь магадгүй япон хүний хийсэн Монголын нууц товчооны монгол хөрвүүлэг ба орчуулгын анхны оролдлого хэмээн үзэж болно. Мөн монгол хэл бичгийг заах зорилгоор Монголын нууц товчооныг сурах бичигт оруулсан анхны тохиолдлуудын ч нэг юм. Үүний урьд Оросын монголч эрдэмтэн А.М.Позднеев 1895/1896, 1896/1897 оны хичээлийн жилд Санкт-Петербургийн Улсын Их Сургуульд уншсан Монголын утга зохиолын түүхийн лекцдээ “Монголын утга зохиолын түүхийн талаарх лекцийнхээ дараачийн хэсгийг бид Юань-чао би-ши зохиолыг унших болон нарийвчлан судлахад зориулах ба энэ зохиолыг орчин үеийн монгол бичгээр сэргээж гаргана” хэмээж байсан нь дээр өгүүлсэн *Транскрипция палеографического текста Юань-чао ми-ши* [Юань-чао ми-ши хэмээх сурвалжийн эртний бичлэгийн галиг] гэдэг бүтээл байв.

⁸ Цэнд гүнгийн амьдрал, үйл ажиллагаа, Монголын нууц товчооныг хэний хүсэлтээр, хэдийд, хэрхэн орчуулсан, түүний орчуулга, хөрвүүлэг өдгөө хаана хаана хадгалагдаж буй талаар дараах бүтээлээс дэлгэрүүлэн үзнэ үү: (Цэнд гүн ба... 2020).

Дүгнэлт

“Монгол үг бичиг” дэвтэрт буй Монголын нууц товчоон нь хэдийгээр зөвхөн 1-р бүлэг буюу 1-68-р зүйлийн хөрвүүлэг боловч эрдэм шинжилгээний хувьд дээр дурдсан олон чухал шинж чанарыг агуулсан бүтээл юм. Гэтэл бидний мэдэж буйгаар одоо болтол “Монгол үг бичиг” дэвтэрт буй энэхүү Монголын нууц товчооны талаар эрдэм шинжилгээний хүрээнд ямар нэгэн танилцуулга буюу судалгааны бүтээл хараахан гараагүй байна. Тиймээс энэхүү хөрвүүлэг нь олон улсын Монголын нууц товчоон судлалын хүрээнд шинээр мэдэгдэж байгаа чухал нэгэн баримт билээ⁹.

Номзүй

Цэнд гүн ба Монголын нууц товчооны анхны монгол орчуулга. Удиртгал бичиж хэвлэлд бэлд. Б.Түвшинтөгс. Уб., 2020.

Tsogtnaran Kh. *Encyclopedia of studies of The Secret History of the Mongols*. Cologne. 2022.


Камияя Кохэ. 蒙古語入門 [Анхан шатны монгол хэл]. Зэнриншоин хэвлэлийн газар. Тайшогийн 8-р он [1919].

Нака Мичиё. 成吉思汗實錄 [Чингис хааны магад тэмдэглэл]. Токио, Дай Ниппон тошо хэв. газар. 1907.


Сүзүэ Мантаро, Шимунага Кэнжи. 蒙古語大辞典 [Монгол хэлний их тайлбар толь]. Явган цэргийн яам. Кокүшю канкокай хэвлэлийн газар. Шовагийн 8-р он (1933). 1-р дэвтэр. *Монгол-япон хэлний хэсэг*, 3+11 (хавсралт зураг)+2+10+1713. 2-р дэвтэр. *Япон-монгол хэлний хэсэг*, 2+807.

Сүзүэ Мантаро. 蒙古文範 *Specimens of Mongolian writings*. Токио. 1923.


⁹ Бид ойрын хугацаанд уг гар бичмэлийг судалж, гэрэл зургаар хэвлэн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах болно.




Зураг 1




Зураг 2




Зыпар 3.1




Зыпар 3.2




Зыпар 4.1




Зыпар 4.2




Зыар 4.3



Зыар 5



Зураг 6 /Зүүн/




Зураг 6 /баруун/


64
Возстановленный монгольский текст
Юань-чао-ми-ши.

The image shows a photograph of a handwritten Mongolian text, likely a reconstruction of the Yuan-Chao-Mi-Shi manuscript. The text is written in vertical columns, reading from right to left. The script is a cursive Mongolian style. There are several lines of text, with some characters appearing to be in a different script or dialect, possibly indicating a mix of languages or a specific dialectal form. The text is presented as a reconstruction, as indicated by the caption.

Зураг 7.2



Гэрээ бичиг 1



Гэрээ бичиг 2

